


Төслийн сонгон шалгаруулалтай холбоотой асуулт, хариултууд

Асуулт: Зөвхөн бодлогын хэрэгжилттэй холбоотой төсөл хамрагдах уу?

Хариулт: Үгүй. Бодлого боловсруулах циклийн (Доорх зурагт үзүүлсэн асуудлаа тодорхойлох, шийдэл боловсруулах, шийдэх арга замаа олон нийтэд хүргэж таниулах, хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх явцууд) бүх эсвэл аль нэг шатыг агуулсан төсөл байж болно. Гол нь санал болгож буй арга зүйн аль нэгийг сонгон асуудлаа тодорхойлж, төслөө боловсруулна.



Асуулт: Сургалт сурталчилгааны ажил хамрагдах уу?

Хариулт: Хамрагдана. Гэхдээ Сонгон шалгаруулалтын удирдамжид заасан шаардлагыг хангасан тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилготой, хүрэх үр дүнгээ тодорхойлсон байх хэрэгтэй бөгөөд санал болгож буй аргаас хэрхэн, яаж ашиглахаа тодорхой ирүүлээрэй.

Асуулт. Одоо хэрэгжиж буй бодлогын нөлөөллийг сайжруулах ажил байж болох уу?

Хариулт. Болно. Төслийн саналдаа шийдвэрлэхээр зорьж буй асуудал, хүрэх үр дүн болон санал болгож буй гурван аргаас хэрхэн, яаж ашиглахаа тодорхой дурдаарай.

Асуулт. Төслийн саналаа заавал бүрэн боловсруулсан байх хэрэгтэй юу?

Хариулт. Үгүй. Сонгон шалгаруулалтын удирдамжид хавсаргасан Төслийн санал ирүүлэх маягтын дагуу шийдвэрлэхээр зорьж буй асуудал, хэрхэн шийдэх арга зам, хүрэх үр дүнгээ санал болгож буй арга зүйн хүрээнд тодорхой ирүүлээрэй.

Асуулт. Асуултаа утсаар асууж болох уу?

Хариулт. Болно. Хэрэв утсаар тодруулга авах бол төслийн зөвлөхтэй 88110218 утсаар холбогдоно уу.